

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/332/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 261640 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn Ахлах аудитор: П.Амарсанаа Утас: 261640 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn Аудитор: Ж.Нямцэцэг Утас: 261640 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

Г УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ш.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

2024.02.23 № 07/275
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг тайлант онд баталж, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд цахим шинэчлэлийг хэрэгжүүлж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын мэдээллийн нэгдсэн сангийн хүчин чадал, багтаамж, хурдыг нэмэгдүүлэн 561,954.8 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авч, харьяа газруудад шилжүүлж, нийт тоног төхөөрөмжийн 29.5 хувийг шинэчилсэн, Олон нийттэй харилцах албаны ажиллах орчныг бүрдүүлэх зорилгоор 504,036.5 мянган төгрөгийг зарцуулж, студийн өрөөг тохижуулан ашиглалтад оруулж, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор "Мөнгө угаах, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх" чиглэлээр ОХУ-аас ирсэн төлөөлөгчидтэй уулзалт хийх, "Эдийн засгийн гэмт хэрэг", "Дижитал нотлох баримт ба зэрлэг амьтдыг хууль бусаар наймаалах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа" сэдвээр сургалт зохион байгуулах, гадаад хамтын

ажиллагааны хүрээнд 4 улсад зохион байгуулсан айлчлал, арга хэмжээ, сургалтад оролцох арга хэмжээнд нийт 191,331.8 мянган төгрөг, Байцаан шийтгэх ажиллагаа хөтөлбөрийн хүрээнд 29,271.3 мянган төгрөгийн дотоод томилолтын, 72,913.8 мянган төгрөгийн бусад зардал, нийт 102,185.1 мянган төгрөгийг зарцуулсан нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд голлох нөлөөг үзүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

Прокурорын байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангасан, ажлын орчныг сайжруулж, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлсэн, цахим шинэчлэлийг эрчимжүүлсэн, иргэдийн итгэл хүндэтгэлийг хүлээсэн байгууллага болох зорилтын хүрээнд 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 184 ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 94.4 хувийн биелэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,476,280,870.21	3,763,711,265.13
34	УРЬДЧИЛГАА	130,629,956.00	79,798,100.00
34600	Урьдчилж гарсан зардал	130,629,956.00	79,798,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	830,475,542.21	1,168,737,793.13
35400	Хангамжийн материал	750,150,542.21	1,072,237,793.13
35410	Бичиг хэргийн материал	50,564,245.00	54,624,560.00
35420	Аж ахуйн материал	205,389,846.80	216,191,003.80
35430	Сэлбэг хэрэгсэл	12,062,600.00	13,594,790.00
35440	Түлш, шатах тослох материал	14,605,894.41	21,135,692.41
35470	Бусад хангамжийн материал	467,527,956.00	766,691,746.92
35600	Мал амьтад	80,325,000.00	96,500,000.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2,515,175,372.00	2,515,175,372.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	2,515,175,372.00	2,515,175,372.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,094,651,735.97	11,010,209,929.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,094,651,735.97	11,010,209,929.92
39200	Биет хөрөнгө	10,892,285,342.99	9,823,935,270.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,196,951,339.00	5,196,951,339.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(417,031,887.46)	(580,944,544.18)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,423,858,458.00	2,283,738,402.35
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,083,135,327.59)	(1,180,942,026.13)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,907,287,044.99	6,492,007,891.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,863,321,082.25)	(3,118,274,981.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	947,970,038.92	1,072,364,954.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	(447,749,669.87)	(533,765,631.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	368,456,476.70	375,980,476.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	(150,244,829.45)	(192,425,393.21)
39217	Ном	9,244,782.00	9,244,782.00
39300	Биет бус хөрөнгө	1,202,366,392.98	1,186,274,659.88
39301	Програм хангамж	268,895,571.94	268,895,571.94
39302	Хуримтлагдсан элэгдэл	(207,043,838.96)	(223,135,572.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,143,424,660.00	1,143,424,660.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,910,000.00)	(2,910,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,570,932,606.18	14,773,921,195.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	153,313,151.65	130,330,295.74
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,681,748.70	15,562,970.91
41300	Өглөг	15,681,748.70	15,562,970.91
41350	Зээлийн хүүгийн өглөг	118,777.79	-
41360	Бусад өглөг	15,562,970.91	15,562,970.91
41361	Байгууллагад төлөх өглөг	15,562,970.91	15,562,970.91
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	137,631,402.95	114,767,324.83
42200	Урт хугацаат зээл	137,631,402.95	114,767,324.83
42220	Гадаад валют	137,631,402.95	114,767,324.83
42223	Санхүүгийн зээл	137,631,402.95	114,767,324.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,417,619,454.53	14,643,590,899.31
51	Засгийн газрын хувь оролцоо	15,417,619,454.53	14,643,590,899.31
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,994,051,432.99	4,994,051,432.99
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	4,994,051,432.99	4,994,051,432.99
51200	Хуримтлагдсан үр дүн	9,769,824,129.48	8,995,795,574.26
51210	Өмнөх үеийн үр дүн	8,996,758,921.52	9,787,474,171.62
51220	Тайлант үеийн үр дүн	773,065,207.96	(791,678,597.36)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	653,743,892.06	653,743,892.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,570,932,606.18	14,773,921,195.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	14,727,393,761.41	17,532,729,305.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,163,052,261.41	4,901,743,547.35
120	Нийтлэг татварын бус орлого	1,163,052,261.41	4,901,743,547.35
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,126,538,799.41	2,445,224,174.35
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	36,513,462.00	2,456,519,373.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,564,341,500.00	12,630,985,758.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,564,341,500.00	12,630,985,758.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,564,341,500.00	12,630,985,758.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,620,542,657.99	12,761,244,764.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,620,542,657.99	12,761,244,764.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,369,579,759.02	11,132,271,241.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,502,606,709.22	5,465,559,590.63
210101	Үндсэн цалин	2,669,951,435.96	3,058,899,441.80
210102	Нэмэгдэл	1,369,993,166.94	1,492,607,624.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	234,266,000.00	335,635,504.38
210104	Урамшуулал	228,396,106.32	578,417,020.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	563,397,522.71	681,765,830.92
210201	Тэтгэврийн даатгал	385,158,031.17	465,990,069.90
210202	Тэтгэмжийн даатгал	44,821,794.85	54,781,869.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,790,235.40	43,719,895.49
210204	Ажилгүйдлийн даатгал	8,873,904.45	10,655,939.32
210205	Эрүүл мэндийн даатгал	88,753,556.84	106,618,056.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,460,186.49	141,140,306.63
210301	Гэрэл, цахилгаан	60,605,637.26	66,258,725.43
210302	Түлш, халаалт	39,874,202.23	42,247,129.75
210303	Цэвэр, бохир ус	15,752,902.00	12,331,392.45
210304	Байрны түрээс	9,227,445.00	20,303,059.00
2104	Хангамж, бараа материалын зардал	888,039,336.98	804,478,096.82
210401	Бичиг хэрэг	118,521,925.00	146,510,645.00
210402	Тээвэр, шатахуун	151,077,577.82	122,973,578.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	308,194,585.42	312,580,573.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,392,400.00	11,509,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	221,331,294.74	210,903,349.95
2105	Нормативт зардал	3,025,300.00	11,406,060.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,025,300.00	11,406,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,201,133,074.00	692,310,608.00
210604	Урсгал засвар	1,165,630,574.00	692,310,608.00
2107	Томилолт, зочны зардал	82,503,824.00	93,038,387.00
210702	Дотоод албан томилолт	82,503,824.00	93,038,387.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	585,069,661.00	466,837,867.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	375,715,915.20	289,543,121.00
210803	Даатгалын үйлчилгээ	48,212,102.00	47,763,631.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,565,110.00	4,479,115.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,089,000.00	1,969,356.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	111,575,874.80	100,672,800.00
210807	Газрын төлбөр	43,911,659.00	22,409,844.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,418,344,144.62	2,775,734,494.50

Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	242,637,398.36	310,849,577.97
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	484,537,852.00	520,369,312.82
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,691,168,894.26	1,944,515,603.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,250,962,898.97	1,628,973,523.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,568,701,464.00	441,473,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	198,019,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,426,017,354.00	56,854,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	142,684,110.00	186,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	682,261,434.97	1,187,499,823.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	681,950,154.97	1,187,499,823.38
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,106,851,103.42	4,771,484,540.47
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,333,785,895.46	5,563,163,137.83
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	121,922,595.46	2,654,468,996.83
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,211,863,300.00	2,908,694,141.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	773,065,207.96	(791,678,597.36)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	13,628,843,067.93	12,630,985,758.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,190,287.93	-
120	Нийтлэг татварын бус орлого	64,190,287.93	-
120009	Бусад орлого	64,190,287.93	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,564,652,780.00	12,630,985,758.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,564,341,500.00	12,630,985,758.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,564,341,500.00	12,630,985,758.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	311,280.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	311,280.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,867,122,004.93	11,579,317,180.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,867,122,004.93	11,579,317,180.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,616,051,315.96	9,950,343,656.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,519,959,148.14	5,465,559,590.63
210101	Үндсэн цалин	2,626,395,112.60	3,062,655,541.28
210102	Нэмэгдэл	1,435,377,197.10	1,488,851,524.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	231,039,390.36	335,635,504.38
210104	Урамшуулал	227,147,448.08	578,417,020.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	563,397,522.71	681,765,830.92
210201	Тэтгэврийн даатгал	385,194,568.52	465,990,069.90
210202	Тэтгэмжийн даатгал	44,815,810.51	54,781,869.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,782,087.92	43,719,895.49
210204	Ажилгүйдлийн даатгал	8,871,867.59	10,655,939.32
210205	Эрүүл мэндийн даатгал	88,733,188.17	106,618,056.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,254,709.49	141,140,306.63
210301	Гэрэл, цахилгаан	60,605,637.26	66,258,725.43
210302	Түлш, халаалт	41,668,725.23	42,247,129.75
210303	Цэвэр, бохир ус	15,752,902.00	12,331,392.45
210304	Байрны түрээс	9,227,445.00	20,303,059.00

Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	783,911,557.42	812,055,733.82
210401	Бичиг хэрэг	124,836,010.00	134,107,000.00
210402	Тээвэр, шатахуун	131,355,600.00	129,049,104.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	331,475,381.42	313,606,573.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,899,400.00	11,509,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	190,345,166.00	223,783,105.95
2105	Нормативт зардал	193,439,900.00	200,491,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	193,439,900.00	200,491,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,878,251,009.00	1,201,263,545.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,709,885,980.00	475,398,745.00
210602	Тавилга	20,000.00	-
210604	Урсгал засвар	1,168,345,029.00	725,864,800.00
2107	Томилолт, зочны зардал	92,921,824.00	89,237,187.00
210702	Дотоод албан томилолт	92,921,824.00	89,237,187.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	750,740,160.00	547,798,609.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	536,067,545.20	370,631,003.00
210803	Даатгалын үйлчилгээ	48,212,102.00	47,763,631.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,802,589.00	4,479,115.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,089,000.00	1,969,356.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	116,258,874.80	100,804,800.00
210807	Газрын төлбөр	44,310,049.00	22,150,704.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	706,175,485.20	811,031,853.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	240,946,503.20	387,025,099.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	465,228,982.00	424,006,753.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,251,070,688.97	1,628,973,523.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,568,809,254.00	441,473,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	198,019,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,426,017,354.00	56,854,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	142,791,900.00	186,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	682,261,434.97	1,187,499,823.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	681,950,154.97	1,187,499,823.38
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	311,280.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	761,721,063.00	1,051,668,578.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	761,721,063.00	1,051,668,578.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	761,721,063.00	1,051,668,578.00
2200	Дотоод эх үүсвэрээр	761,721,063.00	1,051,668,578.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	761,721,063.00	1,051,668,578.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(761,721,063.00)	(1,051,668,578.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,554,051,432.99	653,743,892.06	8,982,655,585.73	14,190,450,910.78
2	Нягтлан бодох бүртгэлийн	-	-	14,103,335.79	14,103,335.79

Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,554,051,432.99	653,743,892.06	8,996,758,921.52	14,204,554,246.57
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	440,000,000.00	-	-	440,000,000.00
9	Тайлант үеийн үр дүн	-	-	773,065,207.96	773,065,207.96
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,994,051,432.99	653,743,892.06	9,769,824,129.48	15,417,619,454.53
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	17,650,042.14	17,650,042.14
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,994,051,432.99	653,743,892.06	9,787,474,171.62	15,435,269,496.67
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(791,678,597.36)	(791,678,597.36)
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,994,051,432.99	653,743,892.06	8,995,795,574.26	14,643,590,899.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,907,821,500.00	11,443,485,934.62	1,464,335,565.38	88.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,907,821,500.00	11,443,485,934.62	1,464,335,565.38	88.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,417,360,800.00	11,002,012,234.62	1,415,348,565.38	88.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,148,912,800.00	5,465,559,590.63	683,353,209.37	88.9
210101	Үндсэн цалин	2,869,506,400.00	3,062,655,541.28	(193,149,141.28)	106.7
210102	Нэмэгдэл	2,967,506,900.00	1,488,851,524.63	1,478,655,375.37	50.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	299,296,400.00	335,635,504.38	(36,339,104.38)	112.1
210104	Урамшуулал	12,603,100.00	578,417,020.34	(565,813,920.34)	4,589.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	803,105,700.00	681,765,830.92	121,339,869.08	84.9
210201	Тэтгэврийн даатгал	534,325,700.00	465,990,069.90	68,335,630.10	87.2
210202	Тэтгэмжийн даатгал	67,195,000.00	54,781,869.52	12,413,130.48	81.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	53,756,200.00	43,719,895.49	10,036,304.51	81.3
210204	Ажилгүйдлийн даатгал	13,438,900.00	10,655,939.32	2,782,960.68	79.3
210205	Эрүүл мэндийн даатгал	134,389,900.00	106,618,056.69	27,771,843.31	79.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	186,142,600.00	141,140,306.63	45,002,293.37	75.8
210301	Гэрэл, цахилгаан	91,439,700.00	66,258,725.43	25,180,974.57	72.5
210302	Түлш, халаалт	56,729,300.00	42,247,129.75	14,482,170.25	74.5
210303	Цэвэр, бохир ус	18,595,600.00	12,331,392.45	6,264,207.55	66.3
210304	Байрны түрээс	19,378,000.00	20,303,059.00	(925,059.00)	104.8
2104	Хангамж, бараа материалын зардал	824,595,900.00	812,055,733.82	12,540,166.18	98.5
210401	Бичиг хэрэг	140,795,700.00	134,107,000.00	6,688,700.00	95.2
210402	Тээвэр, шатахуун	129,098,100.00	129,049,104.00	48,996.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	324,571,900.00	313,606,573.87	10,965,326.13	96.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,609,000.00	11,509,950.00	99,050.00	99.1

Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	218,521,200.00	223,783,105.95	(5,261,905.95)	102.4
2105	Нормативт зардал	200,535,100.00	200,491,000.00	44,100.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,535,100.00	200,491,000.00	44,100.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,457,616,300.00	1,430,656,205.00	26,960,095.00	98.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	627,864,100.00	601,153,705.00	26,710,395.00	95.7
210602	Тавилга	21,300,000.00	21,300,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	808,452,200.00	808,202,500.00	249,700.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	99,446,900.00	89,237,187.00	10,209,713.00	89.7
210702	Дотоод албан томилолт	99,446,900.00	89,237,187.00	10,209,713.00	89.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,387,261,800.00	1,370,074,527.00	17,187,273.00	98.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,199,592,800.00	1,192,906,921.00	6,685,879.00	99.4
210803	Даатгалын үйлчилгээ	47,763,700.00	47,763,631.00	69.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	9,723,300.00	4,479,115.00	5,244,185.00	46.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,969,400.00	1,969,356.00	44.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	106,061,800.00	100,804,800.00	5,257,000.00	95.0
210807	Газрын төлбөр	22,150,800.00	22,150,704.00	96.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,309,743,700.00	811,031,853.62	498,711,846.38	61.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	757,904,600.00	387,025,099.80	370,879,500.20	51.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	551,839,100.00	424,006,753.82	127,832,346.18	76.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	490,460,700.00	441,473,700.00	48,987,000.00	90.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	490,460,700.00	441,473,700.00	48,987,000.00	90.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	198,019,100.00	198,019,100.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	84,341,900.00	56,854,600.00	27,487,300.00	67.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	208,099,700.00	186,600,000.00	21,499,700.00	89.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,907,821,500.00	11,443,485,934.62	1,464,335,565.38	88.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,907,821,500.00	11,443,485,934.62	1,464,335,565.38	88.7
310001	Улсын төсвөөс санхүүжих	12,907,821,500.00	11,443,485,934.62	1,464,335,565.38	88.7
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	301	329	(28)	109.3
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	150	164	(14)	109.3
620001	Удирдах ажилтан	11	16	(5)	145.5
620002	Гүйцэтгэх ажилтан	91	86	5	94.5
620003	Үйлчлэх ажилтан	48	62	(14)	129.2
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	150	164	(14)	109.3
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	28	32	(4)	114.3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	48	48	-	100.0
650010	Гэрээт ажилтан	-	14	(14)	-
650012	Шүүгч, прокурор	74	70	4	94.6

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 76.4 сая төгрөгийн 4 зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 60.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 15.9 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу бичиг хэргийн материалын тендерийг зохион байгуулж, 1 аж ахуйн нэгжтэй 65,400.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгэлээр 104,287.3 мянган төгрөг буюу гэрээний үнийн дүнгээс 38,887.3 мянган төгрөгөөр, шатахууны худалдан авалт 156,000.0 мянган төгрөгөөр төсөвлөгдсөн ч гэрээг үнийн дүнгүй хийж, гүйцэтгэлээр 21,662.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн, нэмэлт гэрээ байгуулалгүй худалдан авалт хийсэн.	1	60,549.8			1	60,549.8							
Сургалт, зөвлөгөөн зохион байгуулахдаа төсвийг төлөвлөдөг боловч, холбогдон гарсан зардлуудын гүйцэтгэл, ажлын тайлан мэдээг бэлтгэж, анхан шатны баримт бүрдэл хангаагүй нийт 210,626.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд: "Эдийн засгийн гэмт хэрэг" сэдэвт сургалтад 83,710.8 мянган төгрөг, "Мөнгө угаах, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх чиглэлээр ОХУ-аас ирсэн төлөөлөгчидтэй хийх уулзалтад 33,699.0 мянган төгрөг, "Дижитал нотлох баримт ба зэрлэг амьтдыг хууль бусаар наймаалах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа" сэдэвт сургалт 15,635.2 мянган төгрөг, "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ны	1	-			1	-							

төсөв 77,581.1 мянган төгрөг тус тус төсөвлөж, зарцуулсан.												
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгай зориулалтын хөрөнгийн худалдан авалтыг тусгаж, тушаалаар батлуулаагүй.	1	-					1	-				
Урсгал засварын 14,500.0 мянган төгрөгийн материал, 1,400.0 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх материал, нийт 15,900.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бүртгэсэн.	1	15,900.0					1	15,900.0				
Дүн	4	76,449.8				2	60,549.8	2	15,900.0			

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрсөн асуудалд албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу харьцуулалтын арга хэрэглэхээс зайлсхийж 2 аж ахуйн нэгжээс 33,627.4 мянган төгрөгийн хөрөнгө, 11 аж ахуйн нэгжээс 198,141.3 мянган төгрөгийн бараа материал, 6 аж ахуйн нэгжтэй 115,982.2 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлэх, нийт 347,750.9 мянган төгрөгийн гэрээг судалгаа хийж, үнийн санал аваагүй, босго үнийн хязгаараас доогуур төсөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүйгээр байгуулсан байна.	1	-	1	-		
Дүн	1	-	1	-		